СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Спорт 1-100 тоот, 3 дугаар баг
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг 43065
Утас: (976) 7036-3977,
Цахим шуудан: selenge@sport.gov.mn
Цахим хуудас: https://selenge.sport.gov.mn

2025.12.15 № 267

танай ______________-ны № ______________

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан хүргүүлэв.

ДАРГА У.БАТМӨНХ

C:user/albanbichig2025/jijigtoot A/5

# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилго 1.Идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлэх** | | | | | | | |
| **Зорилт 1. “Ард иргэд, хүүхэд, залуучуудыг биеийн тамирын арга хэмжээгээр дамжуулан бялдаржуулах, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт сургах насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.1. Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах, дүн мэдээг нэгтгэх, дүгнэлт гаргах, сурталчлах | Хамрагдсан хүний тоо | 16100 | 16300 | Бие бялдрын түвшин тогтоох сорилыг 4 болон 10 дугаар сард сорилын төв болон 9 сумын спорт цогцолборт зохион байгуулсан. Сорилын төвд 21 байгууллагын эрэгтэй 406, эмэгтэй 427 нийт 833 иргэнээс, Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Мандал, Сайхан, Цагааннуур, Дулаанхаан, Хүдэр сумын спорт цогцолборын арга зүйчид уламжлалт аргаар 11,499 иргэнээс, нийт 12,332 иргэнээс бие, бялдрын түвшин тогтоох сорил авч сорилын дүн, мэдээг программд шивж оруулсан.Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас эхний хагас жил А үнэлгээ 1608, В үнэлгээ 1700, С үнэлгээ 1381 байсан бол сүүлийн хагас жилд А-2520, В-3123, С-2808 болж нэмэгдсэн. Сорилд хамрагдсан 11,499 иргэний 73,4 хувь нь АВС үнэлгээтэй байна. Өдөр тутмын сорил авч буй үйл явцын мэдээллийг байгууллагын фэйсбүүкт оруулж, Сорилын төвийн үйл ажиллагаа, | 4, 10 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сорил хэрхэн авч байгаа талаар аймгийн иргэдэд сурталчилж ажилласан. | | |
| 2. | Арга хэмжээ 1.1.2<br>“Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-д иргэдээс насны ангиллаар сорил авах, үр дүнг тооцох, судалгаа хийх арга аргачлалыг боловсруулж гаргах, үйлчлүүлсэн иргэдийг фитнесс, иог, усан сэлэлт гэх мэт спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх | Хамрагдсан хүний тоо | 0 | 500 | “Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-д эрэгтэй 406, эмэгтэй 427 нийт 833 иргэнээс сорил авч нас, биеийн онцлогт тохирсон дасгал, хөдөлгөөнийг төхөөрөмжтэй хослуулан хийх зааварчилгаа өгсөн. Сорилд хамрагдсан иргэдийн сорилын дүнг тайлбарлан, хоол зүйн зөвлөгөө, өөрийн биеийн онцлогт тохирсон дасгал хийх зөвлөмжийг өгч “Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв”-ийн дэргэдэх чийрэгжүүлэх төв, фитнес, спиннинг, усан спорт сургалтын төвөөр нийт давхардсан тоогоор 4,840 иргэн үйлчлүүлсэн. | 2-12 сар | 100 |
| 3. | Арга хэмжээ 1.1.3<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн”-ийг улсын хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллолт, хорт зуршил, дасгал хөдөлгөөн, биеийн тамир, спортын арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран өсвөр, залуучууд, насанд хүрэгчид, ахмад, гэр бүл, ахмадын дунд зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 6421 | 6600 | Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийг буцаан татан төвлөрүүлсэн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй. Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг даргын Тамгын газар, Монголын Мөсөн сурын холбоо, “Хан Буурагчингийн мэргэд харваачдын холбоотой хамтран Ерөө суманд Ерөө кап Мөсөн сурын олон улсын нээлттэй харваа тэмцээнийг зохион байгуулж Монгол улс, ОХУ-ын Буриад Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны нийт 130 гаруй тамирчин оролцсон. Үндэсний спортыг олон улсын тэмцээнээр дамжуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж байна. | 2 сар | 100 |
| 4. | Арга хэмжээ 1.1.4<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн | Хамрагдсан хүний тоо | 120 | 150 | Аймгийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран “Бид хамтдаа” спортын 5 төрөлт тэмцээнийг 05 дугаар сарын 10-11- | 5 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тамирын арга хэмжээ зохион байгуулах | | | | ны өдрүүдэд Худэр сумын спорт цогцолборт зохион байгуулж нийт 15 сум, 2 тосгоны 170 гаруй хөгжлийн бэршээлтэй иргэд хамрагдсан. | | |
| 5. | Арга хэмжээ 1.1.5<br>Бүх нийтийг хамарсан алхалт, гүйлт, дугуй, иог, шугаман бужиг, фитнес, гэх мэт спортын төрлүүдээр биеийн тамирын арга хэмжээг "Өртөө Цаг гаргая" уриан дор төрийн болон төрийн бус байгууллагуудтай улирал бүр иргэдийн дунд хамтран зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 6421 | 6600 | "Өртөө Цаг Гаргая" уриан дор бүх нийтийг хамарсан Иргэдийн спортын их наадам, Аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Улсын аварга шалгаруулах тэмцээн Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан нэрэмжит тэмцээн, зэрэг биеийн тамир, спортын 237 төрлийн арга хэмжээг төрийн бус байгууллага, спорт холбоодтой хамтран спортын олон төрлөөр сар бүр зохион байгуулж насны бүлгээр давхардсан тоогоор нийт 102,892 иргэн хамрагдсан. | 1-12 сар | 100 |
| 6. | Арга хэмжээ 1.1.6<br>Иргэдийн дунд Өвөл цагийн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран насны ангиллаар зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 0 | 130 | Биеийн тамир, спортын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/05 дугаар тушаалын дагуу "Хөдөлгөөнөөр эрүүлжье" өвөл цагийн биеийн тамирын арга хэмжээг Сүхбаатар сумын 5-р баг, Хөдөө нуурт спортын гурван төрөлд (олс таталт, гийр өргөлт, сумо бөх) ийн төрлөөр 02 дугаар сарын 22-ний өдөр зохион байгуулж нийт 11 байгууллагын эрэгтэй 66, эмэгтэй 66 нийт 132 албан хаагч хамрагдсан. Арга хэмжээнд зохион байгуулахад Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих зардлаас 1,455,000 төгрөгийг зарцуулсан. | 2 сар | 100 |
| 7. | Арга хэмжээ 1.1.7<br>Ерөнхий боловсролын сургууль, биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа клубийн үйл ажиллагааг дэмжих, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж хамтарч ажиллах | Хамрагдсан хүний тоо | 460 | 500 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газартай хамтран ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж нийт 550 гаруй сурагчид хамрагдсан. Биеийн тамир, спортын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны | 5 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн А/20 дугаар тушаалын дагуу тус арга хэмжээг зохион байгуулахад Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих зардлаас 600,000 төгрөгийг зарцуулсан. | | |
| 8. | Арга хэмжээ 1.1.8<br>Ахмадын нас биеийн онцлогт тохирсон биеийн тамирын арга хэмжээг улирал бүр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягт уриалж дэмжлэг үзүүлэх | Хамрагдсан хүний тоо | - | - | Усанд сэлэлтийн Мастерсын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын усан спорт сонирхогчдын холбоотой хамтран 05 дугаар сарын 29-30-нд зохион байгуулж 17 байгууллагын 178 тамирчин, Хүдэр сумын Засаг даргын нэрэмжит Аймгийн ахмадын аварга шалгаруулах волейболын тэмцээнд 9 сум, 2 тосгоны 20 багийн 170 тамирчин, Аймгийн аварга шалгаруулах софт волейболын тэмцээнийг Сайхан суманд зохион байгуулж 5 сумын 18 багийн 90 тамирчин, нийт 3 төрлийн арга хэмжээнд 438 ахмад хамрагдсан. | 4-6 сар | 100 |
| 9. | Арга хэмжээ 1.1.9<br>Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдын дунд туршлага судлах, биеийн тамир, спортын тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | - | - | Биеийн тамир спортын газрын харьяа Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Мандал, Сайхан, Цагааннуур, Дулаанхаан, Хүдэр сумын спорт цогцолборын арга зүйчдэд Биеийн тамир, спортын тухай хуульд арга зүйчийн талаар, аймаг, сумын засаг дарга нар биеийн тамир, спортын чиглэлээр ямар ажил зохион байгуулж ажиллах талаарх тусгагдсан заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаарх сургалтыг 10 дугаар сарын 03-ны өдөр Баянгол суманд зохион байгуулсан. Мөн энэ үеэр байгууллагын албан хаагчдын дунд волейбол, сагсан бөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг явуулсан. | 8 сар | 100 |
| 10. | Арга хэмжээ 1.1.10<br>Эрэгтэйчүүдийн сонирхлоор нэгдсэн клуб, спортын төрлөөр дамжуулан эрүүл | Хамрагдсан хүний тоо | - | - | БТСУХ төсвийг буцаан татан төвлөрүүлсэн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчилах, зөвлөгөө өгөх, зөв үлгэр дуурайлал үзүүлж буй бүлэг, клубийг дэмжих, сурталчлах | | | | | | |
| 11. | Арга хэмжээ 1.1.11<br>Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхыг дээшлүүлэх, төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтэй иргэдэд зориулсан бүсийн сургалтыг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | - | - | БТСУХ төсвийг буцаан татан төвлөрүүлсэн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | - | - |
| 12. | Арга хэмжээ 1.1.12<br>Иргэд, ажилтан албан хаагчдыг идэвхтэй хөдөлгөөнд хамруулах, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл бий болгосон аж ахуй нэгж байгууллагыг "Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага"-аар шалгаруулах, сурталчлах | Хамрагдсан хүний тоо | - | - | БТСУХ төсвийг буцаан татан төвлөрүүлсэн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | - | - |
| 13. | Арга хэмжээ 1.1.13<br>Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдын дунд биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 625 | 650 | БТСУХ төсвийг буцаан татан төвлөрүүлсэн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | - | - |
| 14. | Арга хэмжээ 1.1.14<br>Биеийн тамир, спортын салбарын улсын III зөвлөгөөнд оролцох | Хамрагдсан хүний тоо | Бүх албан хаагчид | Бүх албан хаагчид | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Биеийн тамир, спортын улсын хороо, Дархан-Уул аймгийн Биеийн тамир, спортын газар хамтран Биеийн тамир, спортын | 10 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | салбарын улсын 3-р зөвлөгөөнийг Дархан хотод 10 дугаар сарын 10-11-нд зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр Удирдах ажилтан, Спорт, Биеийн тамир гэсэн 3 чиглэлд салбар хуралдааныг зохион байгуулсан.<br>Салбарын албан хаагчдын дунд сагсан бөмбөг, 3х3 сагсан бөмбөг, волейбол, софт волейбол, шатар, дартс, ширээний теннисний тэмцээн зохион байгуулагдсан. Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчид спортын бүх төрөлд оролцож сагсан бөмбөгийн эрэгтэй баг 3-р байр, хүрэл медаль, эмэгтэй 3х3 сагсан бөмбөгийн баг 3-р байр хүрэл медаль, шатрын эрэгтэй төрөлд 4-р байр, ширээний теннисний эрэгтэй төрөлд 2-р байр мөнгөн медаль хүртэж нийт 35 байгууллагаас 9-р байрт шалгарсан. | | |
| 15 | Арга хэмжээ 1.1.15<br>Сумдын арга зүйчдийг мэргэжлийн зэрэг олгох сургалтад хамруулах | Хамрагдсан хүний тоо | 0 | 2 | Биеийн тамир, спортын салбарын улсын 3-р зөвлөгөөний үеэр Арга зүйчийн мэргэжлийн зэрэг олгох сургалт 2026 оноос эхлэн шинэ журмаар зохион байгуулагдах болсон тухай мэдэгдсэн тул арга хэмжээ хойшлогдсон. | 11сар | 90 |
| **Зорилго 2. “Спортлог Сэлэнгэчүүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| **Зорилт 2. “Спортлог Сэлэнгэчүүд” хөтөлбөрийн хүрээнд аймгийн иргэдийн дунд насны ангиллаар, биеийн тамирын арга хэмжээг хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах** | | | | | | | |
| 16 | Арга хэмжээ 2.1.1<br>“Сэлэнгэ Марафон” гүйлтийн арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 454 | 500 | Монгол Улсын засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрамын нэрэмжит “Сэлэнгэ Марафон-2025” бүх нитийн гүйлтийн арга хэмжээг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/274 дугаар тоот захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Сэлэнгэ аймагт Монголын хэт | 6 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холын Марафон гүйлтийн холбоотой хамтран амжилттай зохион байгуулсан. “Сэлэнгэ Марафон-2025” бүх нийтийн гүйлтэд Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгон, төрийн байгууллага, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, 21 аймаг, орон нутгаас нийт 1,950 оролцогч оролцсон. | | |
| 17 | Арга хэмжээ 2.1.2<br>Өсвөр үеийнхний дунд Монголын уламжлалт тоглоом, наадгайн арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 20 | 25 | Ардын хувьсгалын 104 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 94 жилийн ойн баярт зориулж шагай шүүрэх, шагай няслах уламжлалт тоглоом, наадгайн 2 төрлөөр өсвөр нас эрэгтэй, эмэгтэй, насанд хүрэгчид эрэгтэй, эмэгтэй төрлөөр зохион байгуулж нийт 46 хүүхэд, насанд хүрэгчид хамрагдсан. | | 100 |
| 18 | Арга хэмжээ 2.1.3<br>Хүн амын амьдралын хэв маяг идэвхтэй хөдөлгөөний мэдлэг, хандлага, дадалтай иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Иргэдийн спортын их наадам”-ыг 17 сумын иргэдийн дунд 3 үе шаттай зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 0 | 0 | Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн, Биеийн тамир спортын Улсын хорооны даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Спортын наадам зохион байгуулах тухай 1/250 тоот бичгийн дагуу Иргэдийн спортын их наадмын анхан шатны тэмцээнийг спортын 7 төрөлд Сэлэнгэ аймгийн 5 бүсэд зохион байгуулсан. Анхан шатны тэмцээнээс шалгарсан иргэдийн дунд Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/220 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 05 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулж Төвийн бүсэд аймгаа төлөөлөн оролцох 127 тамирчныг сонгон шалгаруулсан. Аймгаас шалгарсан 127 тамирчин Дархан-Уул аймагт 2025 оны 05 дугаар сарын 28-30-ний өдрүүдэд Төвийн бүсийн тэмцээнд оролцож сагсан бөмбөгийн 19-30 насны эрэгтэй баг 1-р байр, эмэгтэй | 5 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баг 3-р байр, 31-44 насны эрэгтэй баг 3-р байр, эмэгтэй баг 1-р байр, +45 насны эрэгтэй баг 3-р байр, эмэгтэй баг 2-р байр, волейболын 19-30 насны эрэгтэй баг 1-р байр, эмэгтэй баг 1-р байр, 31-44 насны эрэгтэй баг 3-р байр, эмэгтэй баг 2-р байр, +45 насны эрэгтэй баг 2-р байр, эмэгтэй баг 3-р байр, ширээний теннисний 19-30 насны эрэгтэй 1-р байр, эмэгтэй 3-р байр, 31-44 насны эрэгтэй 2-р байр, эмэгтэй 1-р байр, +45 насны эрэгтэй 1-р байр, эмэгтэй 2-р байр, үндэсний сурын 18-25 насны эрэгтэй төрөлд 2-р байр, эмэгтэй төрөлд 3-р байр, +26 насны эрэгтэй төрөлд 1-р байр, эмэгтэй төрөлд 2-р байр, шатрын эрэгтэй төрөлд 2-р байр, эмэгтэй төрөлд 3-р байр, шагайн харваан 18-55 насанд 1-р байр, үндэсний бөхийн төрөлд багаараа 2-р байрт шалгарсан. Улаанбаатарын бүсийн шигшээ тэмцээнд Төвийн бүсээс Сэлэнгэ аймгаа төлөөлөн оролцохоор 49 иргэн шалгарсан. | | |
| 19 | Арга хэмжээ 2.1.4<br>Аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 0 | 0 | Сэлэнгэ аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын нөхөрсөг тэмцээнийг Засаг даргын тамгын газартай хамтран Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн дугаар А/539 захирамжийн дагуу 11 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, бадминтон, дартс, усанд сэлэлт, ажлын байрны дасгалын төрлүүдээр зохион байгуулсан. Тэмцээнд нийт 37 байгууллагын 715 албан хаагч хамрагдсан. | 11 сар | 100 |
| **Зорилго-3 Спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт-3.1 Үндэсний спортыг хөгжүүлж, уралдаан тэмцээний тогтолцоог боловсронгуй болгож, тамирчдын ур чадварыг ахиулж улс тив дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг бэлтгэн чадваржуулах** | | | | | | | |
| 20 | Арга хэмжээ-3.1.1<br><br>Сэлэнгэ бага олимп Хүүхдийн спортын наадмыг зохион байгуулж, спортын зарим төрлүүдээр улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | | | Аймгийн хэмжээнд 175 секц дугуйланд 4550 тамирчин хичээллэж өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах /Мөсөн сур, Шатар, Даам, Үндэсний бөх, Чөлөөт бөх, Жүдо, Самбо, Сумо, Сагсан бөмбөг, Волейбол, Усанд сэлэлт, Ширээний теннис, Хөнгөн атлетик, Футзал, Дартс, Дугуй, Буудлага, Уран хөдөлгөөнт гимнастик/ 18 төрлийн тэмцээн зохион байгуулж 1351 өсвөрийн тамирчинг, улсын аварга шалгаруулах 22 тэмцээнд 384 өсвөрийн тамирчинг оролцуулсан. Монголын таеквондо академийн спортын 7 дугаар наадам, мөсөн сурын нээлттэй тэмцээн, Футзал U19 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн, буудлагын Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг орон нутагтаа зохион байгуулж нийт 1584 тамирчдыг оролцуулан, “Футзал U19” Залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнд 3 дугаар байр, Буудлага спортын Залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 дүгээр байр байранд шалгарсан. Хүүхдийн Спортын өвлийн VIII наадмын цанын төрлөөр 2 мөнгөн медаль, Хүүхдийн Спортын зуны VIII наадамд спортын 23 төрөлд 237 тамирчин оролцуулан 8 алт, 5 мөнгө, 14 хүрэл медаль, сонгох төрлөөр 1 алт, 1 мөнгө, Хөгжлийн бэршээлтэй 3 төрлийн тэмцээнд 10 тамирчинг оролцуулан 1 алт, 2 мөнгөн хүртэж, Байгууллагын нэгдсэн дүнгээр 6 дугаар байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. | 1-12 сар | 100 |
| 21 | Арга хэмжээ-3.1.2 | Хамрагдсан хүний тоо | | | Биеийн тамир, спортын үйл ажиллагааг зохицуулах журмад нэмэлт өөрчлөлт | 1-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн спортыг дэмжиж мэргэжлийн түвшинд өрсөлдөх тамирчдыг нэмэгдүүлж, амжилтыг үнэлэх. | | | | оруулан Монгол улсын засгийн газрын 05 тоот тогтоолоор “Өөртөө Цаг гаргая” уриан дор бүх нийтийг хамарсан Биеийн тамир, спортын 237 төрлийн арга хэмжээг төрийн бус байгууллага, спорт холбоодтой хамтран сар бүр зохион байгуулж насны бүлгээр давхардсан тоогоор нийт 102,892 иргэн, Улсын аварга шалгаруулах гурван удаагийн тэмцээнд 1584 тамирчин оролцуулан 28 алт, 57 мөнгө, 49 хүрэл медалийг хүртсэн амжилтыг үзүүлсэн. Мэргэжлийн багийн спортыг дэмжих чиглэлээр Монголын таеквондо академи, волейболын идэрчүүд, сагсан бөмбөгийн U17, мөсөн сурын нээлттэй тэмцээн, Буудлага, Хөл бөмбөгийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг аймгийн зЗасаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр орон нутагтаа зохион байгуулж 1500 гаруй тамирчдыг оролцуулан эхний байруудад шалгарсан амжилтуудыг үзүүлснээр түүнд хичээллэх тамирчдын тоо эрс нэмэгдсэн. Тайланд улсын нийслэл Бангкок хотноо зохион байгуулагдсан “Азийн сургуулиудын дундах” Усанд сэлэлтийн нээлттэй тэмцээнд өсвөрийн шигшээ багийн тамирчин А.Хулан, Д.Эрдэнэбаяр нар мэлхий сэлэлтийн төрөлд хүрэл медаль, “Бахрейн-2025” Азийн залуучуудын III наадамд Волейболын төрөлд спортын сургуулийн багш А.Амартүвшин Монгол улсын шигшээ багийн туслах дасгалжуулагчаар 4 тамирчны хамт шалгарч амжилттай оролцож 5-р байрт, “Бахрейн-2025” Азийн залуучуудын III наадам, “Ливан-2025” Ази тивийн аварга шалгаруулах насанд хүрэгчдийн тэмцээнд, Холимог тулааны төрөлд Биеийн тамир, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | спортын газрын Дулаанхан тосгоны арга зүйч Т.Болдбаатар ахлах дасгалжуулагчаар ажилласан амжилт үзүүлж байна. Бадминтоны багийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс анхны мөнгөн медалийг Мандал сумын 4 дүгээр сургуулийн сурагч Э.Өсөх-Ирээдүй хүртсэн амжилт гаргасан. Мөн аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр тийболын улсын аварга шалгаруулах тэмцээнд Сэлэнгэ аймгийн шигшээ баг амжилттай оролцсон. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран "Бид хамтдаа" спортын 5 төрөлт тэмцээнийг 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Хүдэр сумын спорт цогцолборт зохион байгуулж нийт 15 сум, 2 тосгоны 170 иргэн хамрагдсан. Дартсын спортыг Сэлэнгэ аймагт хөгжүүлэхээр байгуулагдсан "Төгс шидэлт" дартсын холбооны үйл ажиллагааг Аймгийн Засаг дарга дэмжин байнгын бэлтгэл, сургалт явуулах байрны асуудлыг шийдвэрлэж өгсөн. | | |
| 22 | Арга хэмжээ-3.1.3<br><br>Өвлийн болон багийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ. | Хамрагдсан хүний тоо | | | Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумын Засаг даргын Тамгын газар, Монголын мөсөн сурын холбоо, "Хан Буурагчингийн мэргэд харваачдын холбоотой хамтран Ерөө суманд Ерөө кап Мөсөн сурын олон улсын нээлттэй харваа тэмцээнийг зохион байгуулж Монгол улс, ОХУ-ын Буриад Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны нийт 130 гаруй тамирчин оролцсон. Үндэсний спортыг олон улсын тэмцээнээр дамжуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж байна. Аймгийн хэмжээнд өвлийн спорт цана, хоккейн спортуудыг суурь баазад нь | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тулгуурлан Түнхэл, Бугант, Хүдэр суманд хөгжүүлж уг спортын төрлүүдэд 120 хүүхэд, залуучууд, ахмадууд хичээллэж байна. Цана, хоккейн спортуудад хичээллэхэд спортын хэрэгсэл нь өртөг өндөртэй спорт учраас эдийн засгаас шалтгаалан хүүхэд, залуучууд сонирхол ихтэй ч хичээллэх боломж нөхцөл муу байна. Хүүхдийн спортын өвлийн VIII наадамд 2 насны ангиллаар 28 тамирчныг оролцуулан шигшээ тэмцээнд бага насны ангилалд 4 байранд, том нас 5 дугаар байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн.<br>Цанын спортын төрлөөр насны ангиллаар 6 тамирчинг оролцуулан бага насны ангилалд тамирчин Х.Шинээ 500, 1500 м 2 зайд мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Үндэсний спортын 4 төрлийг аймаг, орон нутагт хөгжүүлэн ёс жаяг, уламжлалыг сэргээн 560 гаруй тамирчид хичээллэн Үндэсний бөхийн төрлөөр өсвөр, цолтой цолгүй бөхчүүдийн аймгийн аварга, иргэдийн спортын наадмын үндэсний бөхийн тойргийн барилдаан зэрэг 3 тэмцээнд 160 гаруй бөхчүүд, шагайн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 21 баг, клубийн 132 тамирчин, үндэсний сурын мөсөн харваа, үндэсний сурын аймгийн аварга шалгаруулах, иргэдийн наадмын сурын харваа зэрэг 3 төрлийн тэмцээнд 150 гаруй харваачид оролцсон. | | |
| 23 | Арга хэмжээ-3.1.4<br>Шигшээ багийн үйл ажиллагааг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх | Хамрагдсан хүний тоо | | | 2025 онд медальтан тамирчдыг нэмэгдүүлэх зорилтыг тавин Улсын аварга шалгаруулах 19 тэмцээнд 384 тамирчинг оролцуулан 28 алт 57 мөнгө 49 хүрэл, Монголын хүүхдийн спортын наадамд 23 төрөлд 237 тамирчин оролцуулан 8 алт, 5 мөнгө, 14 хүрэл медаль, | 1-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сонгох төрлөөр 1 алт, 1 мөнгө, Хөгжлийн бэршээлтэй 3 төрлийн тэмцээнд 10 тамирчинг оролцуулан 1 алт, 2 мөнгөн хүртэж, Байгууллагын нэгдсэн дүнгээр 6 дугаар байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. Нийт 35 алт, 66 мөнгө, 63 хүрэл, бүгд 164 медаль хүртэж медалийн чанарыг 20,7 хувиар өсгөсөн. Архангай аймгийн Цэцэрлэг хотод зохион байгуулагдсан Модон барилдааны "MAS Wrestling"-ийн 7 дахь удаагийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 300 орон оролцсоноос Сэлэнгэ аймгаа төлөөлөн оролцсон баг тамирчид 1 алт, 3 мөнгө, 13 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан. | | |
| 24 | Арга хэмжээ-3.1.5 Спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандартуудыг сайжруулан аймгийн хэмжээнд спортын төрлийн стандартын техник хэрэгслийг нэмэгдүүлэн сурталчилах ажлыг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | | | Биеийн тамир, спортын улсын хорооноос 122,0 сая төгрөгийн өртөгтэй Бадминтоны 3 иж бүрдэл шал, чөлөөт бөхийн 72 ширхэг дэвжээ, 12х12 харьцаатай дэвжээний бүтээлэг хүлээн авч сургалт, дасгалжуулалтын үйл ажиллагаандаа хэрэглэж, Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын дунд Бадминтоны тэмцээнийг зохион байгуулж сурталчлах | | |
| 25 | Арга хэмжээ-3.1.6 Ахмадуудын дунд спортын төрлөөр арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | | | Хүдэр сумын Засаг даргын ивээл дор Сэлэнгэ аймгийн ахмадын аварга шалгаруулах Волейболын тэмцээнд 9 сум, 2 тосгоны 20 багийн 170 гаруй тамирчид 4 насны ангилалд, Сэлэнгэ аймгийн Сагсан бөмбөгийн холбоотой хамтран ахмадын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 5 насны ангиллаар зохион байгуулж, 5 сумын 15 багийн 160 гаруй тамирчдыг хамруулсан. Сайхан суманд зохион байгуулагдсан софт волейболын Ахмадын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 27 багийн 130 гаруй | 1-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ахмад волейболчид хамрагдсан. Ахмадын дунд ширээний теннис, граундгольф, софт волейбол, волейболын төрлөөр 200 гаруй ахмадууд хичээллэж байна. | | |
| 26 | Арга хэмжээ-3.1.7 Шинээр хөгжиж буй төрлүүдийг дэмжин мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | Хамрагдсан хүний тоо | | | 2006 оны 269 тоот захирамжийн дагуу 2025 онд шигшээ багийг спортын 4 төрлөөр (Бадминтон, Буудлага, Хөнгөн атлетик, Усан сэлэлт) нэмэгдүүлж 77 тамирчин 4 багштай хичээллэж байна. Мөн шинээр хөгжиж буй Дартс, Грандгольф, Кронхол, Модон барилдаан зэрэг спортыг дэмжин холбоог байгуулан анхны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг хамтран зохион байгуулж эдгээр төрлөөр 4 секц дугуйлан 2 холбоо нэмэгдэн хичээллэж байна. Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр Бадминтон, Тийбол спортыг хөгжүүлж биеийн тамирын 2 багшийг тийболын сургалтад хамруулж улсын аварга шалгаруулах тэмцээнд шигшээ багыг оролцуулсан. Бадминтоны төрлийг Мандал сум, орон нутагт хөгжүүлснээр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж бадминтоны багийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс анхны мөнгөн медалийг Мандал сумын 4 дүгээр сургуулийн сурагч Э.Өсөх-Ирээдүй хүртсэн амжилт гаргасан. | 1-12 сар | 100 |
| 27 | Арга хэмжээ-3.1.8 Усан спортоор хүүхэд, залуучууд, иргэдийг хичээллэх боломжоор хангаж усан сэлэлтийн тэмцээнийг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 1 | Усан спортоор үйлчлүүлэгчдийн тоог 900 хүргэнэ. | Усан спортын төвд иргэдэд үзүүлэх үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулахаар 1 тонны халаалтын 2 ширхэг халаагуурыг 13,2 сая төгрөгөөр авч шинээр суурилуулсан. Усан спортоор хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, иргэн бүрд сэлэлтийн техник зааж сургах чиглэлээр 2 удаа аймгийн болон Сүхбаатар сумын аварга шалгаруулах | 1-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэмцээнийг зохион байгуулан түүнд 27 аж ахуй нэгж байгууллагын 82 тамирчин оролцсон. Улсын хэмжээний Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах ангийн 51 албан хаагчдад 14 хоногийн сургалтыг зохион байгуулж, 2025 онд усан спортоор үйлчлүүлж байгаа 13,781 иргэдэд усан спортын мэдээллээр хангаж, анхан шатны мэдлэгийг зааж сурган заавар зөвлөмжийг өгч ажиллаж байна. Усанд сэлэлтийн насанд хүрэгчид, Мастерсын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа хүлээн авч, Монголын усан спорт сонирхогчдын холбоотой хамтран зохион байгуулж тэмцээнд нас тус бүрт аймаг, хот, дүүргийн 17 багийн 178 тамирчин оролцож Сэлэнгэ аймгийн баг тамирчид 4 мөнгө, 9 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | | |
| 28 | Арга хэмжээ-3.1.9<br>Тамирчин, дасгалжуулагчдын ажлын бүтээмжийг үнэлэх урамшуулах хөшүүргийг бий болгох | Хамрагдсан хүний тоо | | | Аймаг, сумдын Засаг дарга нар дэмжин төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан 117 хүнийг шагнаж урамшуулсан. Монголын Хүүхдийн спортын наадамд оролцож медаль хүртэж амжилт гаргасан 56 тамирчинд 58.5 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. | 1-12 сар | 100 |

**Зорилго-4 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах**

**Зорилт-4.1 Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | Арга хэмжээ 4.1.1<br>Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төсөл боловсруулж хүргүүлэх | Төслийг боловсруулж хүргүүлэх | - | Төслийг боловсруулж, батлуулахаар хүргүүлсэн | Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг 6 зорилтоор 38 арга хэмжээг төлөвлөн жилийн байдлаар 38 арга хэмжээг зохион байгуулсан. | 1-12 сар | 100 |
| 30 | Арга хэмжээ 4.1.2<br>Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах | Биелэлт нэгтгэсэн тоо | 100% | 2 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гарган холбогдох газруудад хүргүүлсэн. | 6,12 сар | 100 |
| **Зорилт-4.2 Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 31 | Дэд арга хэмжээ 4.2.1<br>Байгууллагын албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах | Нийт албан хаагчдын мэдлэг, чадвар дээшлүүлсэн байх | 1 | төлөвлөгөөний хэрэгжилт | Байгууллагын алба хаагчдын онол эрх зүй, хуулийн болон ёс зүйн мэдлэг олгох соён гэгээрүүлэх сургалтын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Удирдлагын Академийн 18 цагийн мэргэшүүлэх сургалт,"БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ-ТӨРИЙН АЛБАНЫ МАНЛАЙЛАЛ" төвийн бүсийн зөвлөгөөний Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэглээ, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийн сургалтад албан хаагчдыг хамруулсан. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан MONGOLIA БҮСЧИЛСЭН ЗӨВЛӨГӨӨН-д хийт албан хаагчдыг хамруулсан. Монгол Улсын Авлигатай тэмцэх газраас орон даяар зохион байгуулж буй "Авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалт, өдөрлөг"-т нийт бүрэлдэхүүн хамрагдсан. Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, цахим технологийн хэрэглээ сэдэвт хэлэлцүүлэг бoлж, "Төрийн | 1-12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албан хаагч эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих төрийн албан дахь удирдах түвшний жендэр"-ийн сургалт, Үндэсний архивын ерөнхий газрын 16 цагийн мэргэшүүлэх сургалт, Сэлэнгэ аймгийн Төрийн Архивын хэлтсийн дарга Хишигням Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэйн Г.Буянхишиг "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Нарны алтан оньс" Төрийн бус байгууллагын соё гэгээрүүлэгч сургагч багш нар "Ёс зүй" сэдвээр соён гэгээрүүлэх сургалт, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан Залуучуудын хөгжлийн төлөөх түншлэл, салбар дундын уялдаа холбоо үндэсний чуулган, Шинэчлэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяны хүрээнд "ЭККО-ФАРМ" төсөлтэй хамтран зохион байгуулсан. Жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн мэдлэг, ойлголт олгох сургалт, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Баярсүрэн "Авлигын эсрэг хууль"-ийн талаар, Аймгийн Онцгой байдлын газартай хамтран Галын аюулгүй байдал, ХАБЭА-ын сургалт, Монгол Улсын Авлигатай тэмцэх газраас орон даяар зохион байгуулж буй "Авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалт, өдөрлөг"-т нийт бүрэлдэхүүн хамрагдсан. Биеийн тамир, спортын салбарын Улсын зөвлөгөөн, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаар Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Урьдчилан сэргийлэх, шуурхай удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Батсүрэн, ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Э.Энхнамар нар сургалт, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газартай хамтран Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжоор сургалт сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээг таним болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Сорилын төвийн арга зүйчдийг байгууллагын бодлогоор мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулсан. Биеийн тамир, спортын Улсын хорооны Биеийн тамирын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Баасан, судлаач, дэд профессор Ж.Тунгалаг, “Andromeda” ХХК-ны хөгжүүлэлт хариуцсан төслийн менежер С.Ганбаяр, хоол зүйч Г.Сэвжид нартай хамтран “Сорилын төвийн сургалт”-ыг онол практик хосолсон сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар, Баянгол, Налайх дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны арга зүйч нарт танхимаар, Архангай аймгийн Биеийн тамир, спортын газрын арга зүйчдийг цахимаар хамруулсан сургалтыг зохион байгуулсан.<br>Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан Монголын залуучуудын эвсэл ТББ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, EU Delegation to Mongolia, UNFPA Mongolia "ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ:САЛБАР ДУНДЫН УЯЛДАА" үндэсний чуулганд хамрагдсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
